

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
Стратегийн зорилт 6. Төрийн захиргааны удирдлага, зохион байгуулалтыг хангах, салбарын хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх							
	Зорилт 1. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд дотоод сургалтын төлөвлөгөөг батлуулах, сургалтыг тухай бүр зохион байгуулахад нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.		Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар албан хаагчдыг сургаж, хөгжүүлэх, тэдний ажлыг үнэлсэн эсэх	1	1	1	100
1	Арга хэмжээ 1.1. Албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг шинэчлэн баталж хэрэгжүүлнэ.	Урсгал зардал	Тайлангийн тоо	1	1	Хөдөлмөрийн дотоод журам", "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр", "Ахмадын санг ажиллуулах журам", "Албан томилолтын журам", "Салбарын шагнал олгоход мөрдөх журам"-ын төслийг хэлтсийн албан хаагчдын хамт боловсруулан батлуулсан.	100
2	Арга хэмжээ 1.2. Сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ.	Урсгал зардал	Төлөвлөгөө Тайлангийн тоо	- -	1 1	Албан хаагчдын дотоод сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн ... дугаар тушаалаар баталсан.	100
3	Арга хэмжээ 1.3. Албан хаагчдын ажлын үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг зохион байгуулна.	-	Үнэлгээ хийх ажлыг зохион байгуулсан тоо	2	2	Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, баталгаажуулах чиг үүрэг бүхий үнэлгээний багийг жилд 1 удаа байгуулахаар заасан бөгөөд 2025 оны "Үнэлгээний баг"-ийн бүрэлдэхүүнийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/184 дүгээр тушаалаар баталж, 2024 оны эхний хагас жилийн үнэлгээ хийх ажлыг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан.	100

Зорилт 2. Яам болон харьяа байгууллагын сул орон тоог холбогдох журмын дагуу нөхнө.		-	ТАЗ-д сул орон тооны захиалга хүргүүлсэн болон тусгай шалгалт зохион байгуулсан эсэх Тийм-1, Үгүй-0	4	1	3 2	100
4	Арга хэмжээ 2.1. Төрийн албаны зөвлөлд сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын захиалга хүргүүлнэ.		Захиалга хүргүүлсэн эсэх Тийм-1, Үгүй-0	4	1	1.Яамны сул орон тооны мэдээллийг 3 удаа нээлттэй мэдээлсэн. 2.Төрийн албаны зөвлөлд нийт сонгон шалгаруулалтын 3 удаагийн нийт 14 орон тооны захиалга хүргүүлж, 2 удаа шалгалт зохион байгуулан 12 сул орон тоог нөхсөн.	100
5	Арга хэмжээ 2.2. Төрийн албаны зөвлөлийн Цахим хөгжил, харилцаа холбооны яамны дэргэдэх салбар зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлэх, тусгай шалгалтыг зохион байгуулна.	-	Тайлангийн тоо Тусгай шалгалт зохион байгуулсан эсэх Тийм-1, Үгүй-0	1 4	1 1	Тусгай шалгалтын 2025 оны 05 дугаар сарын 06, 12-ны өдөр зохион байгуулсан.	100
Зорилт 3. Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж, хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлнэ.		-	Хүргүүлсэн эсэх Тийм-1, Үгүй-0	Цахима ар-12	1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тайлан-3	100
6	Арга хэмжээ 3.1. Монгол Улсын Засгийн газрын хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлангуудыг нэгтгэн боловсруулж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн эсэх Тийм-1, Үгүй-0	Цахима ар-6	1	Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын хавсралтаар батлагдсан тайлагнах цаглабарын дагуу 2025 оны 07 дугаар сард тайлагнахаар өөрчлөгдсөн. Хугацаа болоогүй.	-
7	Арга хэмжээ 3.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг удирдлагад танилцуулан хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг	-	Хүргүүлсэн эсэх Тийм-1, Үгүй-0	Цахима ар-12	1	1.Тус яамны 2025 оны 1 дүгээр улирлын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэн 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр цахим системд тайлагнаж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт нотлох баримтын хамт хүргүүлсэн.	100

	нэгтгэн боловсруулан Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлнэ.					2.Ерөнхий сайдын 2025 оны захирамжийн дагаа тус яамны хэрэгжилт хангалтгүй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт болон Ерөнхий сайдын шуурхайн 3 үүрэг даалгаврын биелэлтийг гарган 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар гарган 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр цахим системд тайлагнаж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт нотлох баримтын хамт хүргүүлсэн. 3.УИХ-ын 2024 оны 52 дугаар тогтоолын биелэлтийг нэгтгэн Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газарт 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр хүргүүлсэн.	
	Зорилт 4. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлүүлэх ажлыг зохицуулах, шийдвэрлэлтэд хяналт тавих, тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.	-	Шийдвэрлэлтийн дундаж хоногийг 15%-иар бууруулах Тайлангийн тоо	Шийдв эрлэлт ийн дундаж 29 хоног, 21 цаг, 32 минут	Шийдвэ рлэлтий и дундаж 27 хоног	1.Иргэдээс тус яам болон албан тушаалтанд хандан нийт 65 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлсэн байна. Иргэд олон нийттэй харилцах төв 11-11-ээс ирүүлсэн 30, байгууллага бүртгэсэн 35 өргөдөл, гомдол, санал, хүсэлт. /Өмнөх оны 12 сард ирсэн 10 өргөдөл, гомдлыг 2025 онд шийдвэрлэсэн/ Нийт 65 өргөдөл, гомдол ирүүлснээс хугацаандаа байгаа 20, хугацаа хэтэрсэн 6, шийдвэрлэсэн 39 Шийдвэрлэлтийн дундаж 31 хоног, 13 цаг, 14 минут	80
	Зорилт 5. Сайд болон Төрийн нарийн бичгийн дарга нарын хуралдааныг зохион байгуулах, хуралдааны тэмдэглэл хөтөлж, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг гаргана.	-	Зохион байгуулсан хуралдааны тоо Хуралдааны тэмдэглэлийн тоо Өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	18	1	Хуралдааны тоо 10	100
8	Арга хэмжээ 5.1. Сайдын зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, хуралдааны тэмдэглэл хөтлөх, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавина.	-	Зохион байгуулсан эсэх Тийм-1, Үгүй-0 (Хуралдааны тэмдэглэлийн тоо)	-	1	Зөвлөл хуралдаагүй болно.	-
9	Арга хэмжээ 5.2. Сайдын шуурхай хуралдааныг	-	Зохион байгуулсан эсэх	3 3	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын шуурхай хурал 2025.01.07, 2025.01.21, 2025.02.18,	100

	зохион байгуулах, хуралдааны тэмдэглэл хөтлөх, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавина.		Тийм-1, Үгүй-0 (Хуралдааны тэмдэглэлийн тоо)			2025.03.11, 2025.05.02-ны өдрүүдэд 5 удаа хуралдаж, хуралд оролцогч албан хаагчдын бүртгэл, хурлын тэмдэглэл хөтөлж, сайдын шуурхай хурлаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг цаг, хугацаанд нь нэгтгэн сайдын ажлын алба болон Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газарт тус, тус хүргүүлсэн.	
10	Арга хэмжээ 5.3. Төрийн нарийн бичгийн даргын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулах, хуралдааны тэмдэглэл хөтлөх, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавина.	-	Зохион байгуулсан эсэх Тийм-1, Үгүй-0 (Хуралдааны тэмдэглэлийн тоо)	15 15	1	Төрийн нарийн бичгийн даргын 5 удаагийн шуурхай хуралдааныг зохион байгуулж, хуралдааны тэмдэглэл хөтлөн өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг холбогдох газар хүргүүлэн ажилласан.	100
11	Арга хэмжээ 5.4. Байгууллагын аппаратын жилийн үйл ажиллагааны тайлангийн хурал болон нэгдсэн хурлыг зохион байгуулна.		Зохион байгуулсан эсэх Тийм-1, Үгүй-0 (Тоогоор)	-	1	Хугацаа болоогүй.	-
Зорилт 6. Төрийн шагналын материалыг ЗГХЭГ-т уламжлах, Мэдээлэл, харилцаа холбооны салбарын шагналыг олгох болон байгууллагын ахмад настны судалгаа хийж, хүндэтгэлийн арга хэмжээг тус тус зохион байгуулна.							
		-	Шагнагдсан эсэх Арга хэмжээний тоо Шагналын цахим систем нэвтэрсэн эсэх	1 2 -	1 2 1	Арга хэмжээний тоо 2	100
12	Арга хэмжээ 6.1. Төрийн шагналын материалыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт уламжилна.	-	Төрийн дээд шагналыг тодорхойлсон эсэх Тийм-1, Үгүй-0	2 124 олгосон	1	Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 104 жилийн ойн баяр, Монгол улсад орчин цагийн цагийн мэдээлэл харилцаа холбооны салбар үүсэж хөгжсөний 104 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан Төрийн дээд шагналаар шагнуулахаар ирүүлсэн 131 салбарын албан хаагч, ахмад настны шагналын материалыг хүлээн авч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт уламжлахаар ажиллаж байна.	90
13	Арга хэмжээ 6.2. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын шагналын	-	Олгосон салбарын шагналын тоо	1612 1	1 1	"Дэлхийн мэдээлэлжсэн нийгмийн өдөр"-ийг тохиолдуулан Цахим, хөгжил инновац харилцаа холбооны сайдын 2025 оны 04 дүгээр сарын 21-ны	100

	журмыг шинэчлэн баталж, олгох ажлыг зохион байгуулна.		Тийм-1, Үгүй-0 Журам шинэчилсэн эсэх			өдрийн А/60 дугаар тушаалаар салбарынхаа хөгжилд оруулсан хувь нэмэр, ажлын амжилт, бүтээлийг нь үнэлэн нэр бүхий инженер, техникийн ажилтан, албан хаагчид, ахмад настанд ... шагнал олгосон. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 104 жилийн ойн баяр, Монгол улсад орчин цагийн цагийн мэдээлэл харилцаа холбооны салбар үүсэж хөгжсөний 104 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан 24 байгууллагаас албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч холбогдох журмын дагуу хянан сайдын тушаалаар албажуулж шийдвэрлэхээр ажиллаж байна.	
14	Арга хэмжээ 6.3. Салбарын шагналын цахим системийг хөтлөх, цахим архив үүсгэх, мэдээллийн санг баяжуулах, хөгжүүлэх ажлыг зохион байгуулна.	-	Шагналын цахим системийг нэвтрүүлсэн эсэх	-	1	Салбарын шагналын цахим системийг хөтлөх, цахим архив үүсгэх, мэдээллийн санг баяжуулах, хөгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.	100
15	Арга хэмжээ 6.4. Байгууллагаас өндөр настны тэтгэвэрт гарсан ахмад настныг Цагаан сарын баяр, Ахмадын баярын өдрийн хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулна.	-	Арга хэмжээний тоо	2	2	Монгол Улсын Их Хурлаас ахмад үеийн туршлага солилцох "Туршлага бол хүч" уриа дор хэрэгжүүлж буй "Нээлттэй парламент: Эксперт" хөтөлбөрт тус яамны Ахмадын зөвлөлийн 2 гишүүнийг parliament.mn цахим бүртгэлд бүртгүүлсэн. Цагаан сарын баярыг тохиолдуулан 34 ахмадыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлсэн. Цаашид Ахмадын баяраар салбарын ахмад настанд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулж ажиллана.	100
Зорилт 7. Газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, аймаг, нийслэлийн Засаг дарга, салбар байгууллагын удирдлага нартай 2024 онд хамтран ажиллах гэрээ байгуулах, батлуулах, хэрэгжилтийг тайлагнана.		-	Батлуулсан төлөвлөгөөний тоо Гэрээний тоо	2 22	2 22	Батлуулсан 1	100
16	Арга хэмжээ 7.1. Газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн биелэлтийг тайлагнана.	-	Нэгтгэсэн төлөвлөгөө Тайлангийн тоо	1 2	1 2	Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны эхний хагас жилийн биелэлтийг 06 дугаар сарын 13-ны өдөр, Төрийн захиргааны удирдлагын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 06 дугаар	100

						сарын 12-ны өдөр Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн.	
17	Арга хэмжээ 7.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2025 онд хамтран ажиллах гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, гэрээний биелэлтийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлнэ.	-	Гэрээний тоо Биелэлтийг хүргүүлсэн эсэх Тийм-1, Үгүй-0	22 1	22 1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2025 онд хамтран ажиллах гэрээг 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр байгуулсан. Гэрээний 2025 оны эхний хагас жилийн биелэлт гаргах хугацаа болоогүй байна.	100
Зорилт 8. Жендерийн салбар зөвлөлийн 2025 оны төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.			Батлуулсан төлөвлөгөөний тоо Хүргүүлсэн тайлангийн тоо	1 1	1 1	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, салбар дундын стратеги төлөвлөгөө /2022-2031/, Жендерийн үндэсний хорооны 2025 оны төлөвлөгөөг үндэслэн 2025 онд хийх ажлын төлөвлөгөө гаргаж, харьяа, салбар газруудад хүргүүлэн тогтоосон хугацаанд тайланг авч нэгтгэн Жендерийн үндэсний хороонд хүргүүлэн ажилласан. Азийн эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр, Жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого хэлэлцүүлэгт холбогдох албан хаагчдыг хамруулж, оролцуулсан. Жендерийн тэгш бус байдал, жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бууруулахад залуучууд, олон нийтийн жендерийн боловсролыг нэмэгдүүлэх мэдээ мэдээллийг түгээх, бодлогын нөлөөллийн аяны хүрээнд харьяа, салбар байгууллагууд цахим хуудаст богино, шторк, контентоор олон нийтэд мэдээлэл түгээсэн.	100
Зорилт 9. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажлын байрны дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургалтын хөтөлбөр батлуулна.		-	Хөтөлбөр боловсруулсан эсэх	-	1	Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажлын байрны дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалтыг дотоод сургалтын төлөвлөгөөнд тусгасан.	30
Зорилт 10. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс сэргийлэх, хүний эрхийн боловсролыг олон нийтэд		-	Сургалтын тоо	-	1	Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 89 дүгээр захирамжаар ялгаварлан гадуурхалтын эсрэг авах арга хэмжээний талаар судалгаа хийж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хуулийн төсөл	30

түгээх, дэмжих, сургалт зохион байгуулна.						боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтан, мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах, мэдээлэл, судалгаа гаргуулах, дүн шинжилгээ хийлгэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулахыг тус ажлын хэсгийн ахлагч УИХ-ын О.Саранчулуунд үүрэг болгосны дагуу дэд ажлын хэсэгт орж, ажилласан. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс сэргийлэх, хүний эрхийн боловсролыг олон нийтэд түгээх, дэмжих, сургалт зохион байгуулах ажлын хүрээнд байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөнд саналаа хүргүүлсэн.	
Зорилт 11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний орон тосны бус дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.		-	Баталсан төлөвлөгөө		1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/83 дугаар тушаалаар салбарын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хангахад чиглэсэн хууль, тогтоомж, төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг, бүхий "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, харилцаа холбоо, мэдээлэл, технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах талаар харьяа салбар байгууллагуудад 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 02/1377 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	100
Зорилт 12. Яамны албан ёсны цахим хуудасны хөтлөлтийг хариуцан зохион байгуулж, үйл ажиллагааны ил тод байдлыг хангана.		-	Олон нийтэд мэдээллийг ил тод байршуулсан тоо	208	68	I-IV	100
18	Арга хэмжээ 12.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу нийтэд байнга,	-	Мэдээллийн тоо	50	68	Яамны албан ёсны цахим хуудас (www.mddc.gov.mn)-т Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан "Хаалттай", "Хязгаарлалттай" гэж зааснаас бусад	100

	нээлттэй, ил тод байлгах мэдээллийг байршуулна.					нээлттэй байршуулах шаардлагатай 68 төрлийн мэдээллийг Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/21 дүгээр тушаалын дагуу олон нийтийн мэдэх эрхийг хангах хүрээнд тухай бүр ил тод, нээлттэй байршуулан ажилласан. Хэрэгжилтийн явц 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар цахим систем (www.shilen.gov.mn)-д 98% үнэлэгдсэн.	
19	Арга хэмжээ 12.2. Яамны албан ёсны цахим хуудасны хөтлөлтийг хариуцан зохион байгуулж, үйл ажиллагааны ил тод байдлыг хангана.	-	Мэдээ, материалын тоо	0	Тухай бүр	Яамны албан ёсны цахим хуудас (фэйсбүүк пэйж, веб сайт)-т байгууллагын үйл ажиллагаа, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар нийт 140 мэдээ, материал, постер бэлтгэн нийтэлсэн байна. Үүнд: 1.Төрийн захиргааны удирдлагын газрын-86; 2.Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын-14; 3.Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын-12; 4.Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын-12; 5.Бодлого төлөвлөлтийн газрын-16. Цахим хуудасны Монгол бичгийн хувилбарт мэдээ, мэдээллийг тухай бүр хөрвүүлэн 140 мэдээг нийтэлсэн. Мөн байгууллагын албан ёсны веб сайт хуудасны үндсэн 6, дэд 60 цэсний мэдээллийг тухай бүр шинэчилж, шаардлагатай мэдээ, мэдээллийг 7 газар, 8 хэлтсээс авч нээлттэй байршуулан, олон нийтийг байгууллагын бодлого, үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллээр тогтмол хангаж ажилласан.	100
20	Арга хэмжээ 12.3. Ил тод байдлын тайланг гарган Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн тайлангийн тоо	1	1	Байгууллагын цахим хуудасны "Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн тайлан"-г хугацаанд нь гаргаж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоодын аудитын газарт хүргүүлж, 100% гүйцэтгэлтэй үнэлүүлсэн.	100
Зорилт 13. Байгууллагын хэмжээнд мэдээллийн технологийн үйл ажиллагааг явуулах нөхцөлийг хангана.			Мэдээллийн технологийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангасан эсэх	1	1	20 тоног төхөөрөмж хүлээн авч, ажиллах нөхцөлийг сайжруулсан.	100

			Тийм-1, Үгүй-0				
21	Арга хэмжээ 13.1. Байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай систем, программ хангамж, техник тоног төхөөрөмж нэвтрүүлж, хэрэгжүүлэх, ашиглалтыг сайжруулна.	-	Шинэчилж нэвтрүүлсэн эсэх Тийм-1, Үгүй-0	6	1	“Албан хаагчдын тоног төхөөрөмж, бараа худалдан авах тендер”-ийн тоног төхөөрөмж болох SurFace pro-3 ширхэг, Зөөврийн компьютер-3 ширхэг, дэлгэц-10 ширхэг, Ухаалаг дэлгэц-1, Видео хананы дэлгэц-3 ширхгийг хүлээн авсан. Ухаалаг индрийн хувьд үзүүлэлт зөрсөн асуудал гарч, нийлүүлэгч компанид мэдэгдэн солих шаардлага тавиад байна. Байгууллагад ашиглагдаж байгаа Микрософт оффис 360 программын эрхийг 4 хэрэглэгчид нэмж олгон хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. 18 хэрэглэгчийн компьютерт шаардлагатай тохируулга үйлчилгээг үзүүллээ. Интернэтийн хурдыг 100мб-р нэмэгдүүллээ.	100
22	Арга хэмжээ 13.2. Албан хаагчдын компьютерт гарсан гэмтлийг засварлах, хэвийн ажиллагаатай байлгах, Дотоод үйл ажиллагааны удирдлагын системд мэдээллийг шинэчилнэ.	-	Засварласан эсэх Тийм-1, Үгүй-0	11	1	Албан хаагчдын компьютер тоног төхөөрөмжид гарсан асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. Мөн Дотоод үйл ажиллагааны удирдлагын системд мэдээллийг тогтмол шинэчилж байна.	100
Зорилт 14. Яамны архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг холбогдох хууль, стандарт, дүрэм, журам, зааврын дагуу хөтлөн явуулна.		-	Албан бичгийн эргэлт Архивт хүлээн авсан нэгжийн тоо	7154 263	-	4807	100
23	Арга хэмжээ 14.1. Ирсэн, явсан бичиг болон бичгээр ирүүлсэн өргөдөл, гомдлын бүртгэлийг Дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд хөтөлнө.	-	Бүртгэлийг хөтөлсөн тоо	Ирсэн бичиг 4427 Явсан бичиг 2541	-	Дотоод удирдлагын нэгдсэн системд бүртгэгдсэн нийт бичгийн эргэлт 4807, үүнээс явсан 2510, ирсэн бичиг 2297. Ирсэн бичиг судлагдаж байгаа 552, шийдвэрлэсэн 1652, буцаасан 93 албан бичгийг Дотоод системд бүртгэсэн байна.	100
24	Арга хэмжээ 14.2. Үндэсний бичгийг албан хэрэг хөтлөлтөд нэвтрүүлж хэвшсэн байна.	-	Нэвтрүүлсэн эсэх Тийм-1, Үгүй-0	-	1	Монгол хэлний тухай хуулийн дагуу төрийн албан хэргийг хос бичиг (кирилл болон үндэсний)-ээр хөтлөн явуулж байгаагаар холбогдуулан хэвлэмэл хуудасны эх загварыг кирилл болон үндэсний бичгээр хянан	100

						баталгаажуулж, хэвлүүлэх хүсэлтийг Архивын ерөнхий газарт 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 03/15 дугаартай албан бичгээр хүргүүлж, үндэсний бичгээ р27 нэр төрлийн хэвлэмэл хуудас баталгаажуулж, 2025 онд хэрэглэгдэх үндэсний бичгийн хэвлэмэл хуудас А4-5160, А5-1040, кирилл бичиг А4-2740 ширхэг хэвлүүлж, хүлээн авсан.	
25	Арга хэмжээ 14.3. Яамны 2025 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлуулж, яамны 2024 оны зохион байгуулалтын нэгжүүдийн баримтыг архивт хүлээн авах, хадгалж ашиглуулна.	-	Батлуулсан хөтлөх хэргийн нэрийн жагсаалт Журамд нийцүүлэн нөхөн бүрдүүлсэн тоо Баримт ашиглуулсан тоо	1 Б1474, Т153, 70 жил 5 -	1 - -	"Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны албан бичиг баталгаажуулан илгээх албан тушаалтны индекс", "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжид олгох хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын индекс", "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны хэвлэмэл хуудаст үйлдэх баримт бичгийн нэр төрөл, индекс, хариуцах албан тушаалтан", "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны нэгжийн дотоод албан бичигт илгээх албан тушаалтны индекс"-ийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/61 дүгээр тушаалаар тус тус батлуулсан. Яамны 2024 оны зохион байгуулалтын нэгжүүдийн баримтыг архивт хүлээн авах хуваарийг гаргаж, нийт албан хаагчдад мэдээлэл хүргүүлсэн боловч 4 албан хаагч архивын баримт хүлээлгэн өгсөн. 2024 оны ирсэн, явсан бичгийг эмхлэн цэгцэлж, архивлан архивт 2024 оны 3, 7, 8, 9, 10 дугаар сарын нийт 79 архивын нэгж, 2025 оны 1-5 сарын явсан бичиг 42 хадгаламжийн нэгжийг шилжүүлсэн.	80
Арга хэмжээ 15. Гамшгийн урьдчилан сэргийлэх мэдээг дамжуулах болон гамшгийн үеийн харилцаа холбооны бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.		-	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	89	4	-	30
26	Арга хэмжээ 15.1. Гамшгийн үеийн мэдээлэл, харилцаа холбооны бэлэн байдлын төлөвлөлтийн дагуу яам	-	Дадлага сургуулилтын тоо	1	1	Гамшгийн үеийн мэдээлэл, харилцаа холбооны бэлэн байдлын төлөвлөлтийн дагуу яам болон харьяа, салбар байгууллагын хүрээнд дадлага, сургууилт зохион байгуулахаар төлөвлөн шаардлагатай	-

	болон харьяа, салбар байгууллагын хүрээнд дадлага, сургуулилалт зохион байгуулна.					судалгааг хийн 3 дугаар улиралд хийхээр төлөвлөн ажиллаж байна. Хугацаа болоогүй.	
27	Арга хэмжээ 15.2. Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангана.	-	Тайлангийн тоо	1	1	Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын хэмжээнд зохих байршилд 11 галын хор, бусад шаардлагатай хэрэгслийн бэлэн байдлыг шалган ажиллаж байна. Хугацаа болоогүй.	-
28	Арга хэмжээ 15.3. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүнийг чадавхжуулах, бэлэн байдлыг хангах, сургалт зохион байгуулна.	-	Арга хэмжээний тоо	1	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүнийг чадавхжуулах, бэлэн байдлыг хангах, сургалтыг 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	30
29	Арга хэмжээ 15.4. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны албан хаагчдад "Объектын гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ" сургалт зохион байгуулна.	-	Арга хэмжээний тоо	1	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны албан хаагчдад "Объектын гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ" 3-4 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөөд байна. Хугацаа болоогүй.	-
Зорилт 16. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг батлуулна.		-	Батлуулсан журам	-	1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөлийг Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/94 дүгээр тушаалаар байгуулсан. Тушаалын дагуу байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үлгэрчилсэн журмыг боловсруулсан.	30
Арга хэмжээ 16.1. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ажиллах нөхцөлийг хангах, байрны өрөөнүүдийн цонхыг солиулах, хортон шавжийн устгал ариутгал халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.			Эрүүл, аюулгүй байдлын зөрчил гарсан эсэх Тийм-1, Үгүй-0 Солиулсан цонхны тоо Ариутгалын тоо	-	1		100

Зорилт 17. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, авлигын эсрэг яамны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулна.		-	Тайлангийн тоо Төлөвлөгөө	3 1	4 1	1 1	100
30	Арга хэмжээ 17.1. Нийтийн албан тушаалтны 2024 оны хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг баталгаажуулж, тайлан мэдээг Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.	-	Тайлангийн тоо	1	1	Тус яамны болон харьяа байгууллага (Үндэсний дата төв УТҮГ, И-Монгол академи УТҮГ, Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ)-ын 125 мэдүүлэг гаргагчийн 2024 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг мэдүүлгийн бүрдүүлэлтийн системд баталгаажуулан "Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн 2024 оны тайлан"-г 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 03/348 дугаартай албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.	100
31	Арга хэмжээ 17.2. Авлигын эсрэг төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг тайлагнана.	-	Төлөвлөгөө Тайлангийн тоо	1 1	1 1	Тайлагнах хугацаа болоогүй.	-
32	Арга хэмжээ 17.3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан тус яамнаас хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн тайлагнана.	-	Хэрэгжилтийн тайлангийн тоо	1	2	Тайлагнах хугацаа болоогүй.	-
Зорилт 18. Салбарын санхүү, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтийн нэгдсэн зохицуулалт хийх, хэрэгжүүлнэ.		-	Тоогоор	3 11 2	3 11 2	2 /1 хугацаа болоогүй/ 1	100

33	Арга хэмжээ 18.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн төслийг нэгтгэн, боловсруулж УИХ, Сангийн яам, Үндэсний аудитын газарт хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	3	3	-Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т заасны дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны сайд бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд урсгал зардалд 140.2 тэрбум, хөрөнгө оруулалтын зардалд 125.9 тэрбум төгрөг, нийт 266.1 тэрбум төгрөгийн саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01/740 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. -Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны урсгал зардлын хязгаарын саналд 200.9 тэрбум, хөрөнгө оруулалтын зардалд 88.5 тэрбум төгрөг, нийт 289.4 тэрбум төгрөгийн саналыг Сангийн яаманд 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1386 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 2026 онд Хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 268.9 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 20.5 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлж, 200.9 тэрбум төгрөгийг урсгал төсөвт, 88.5 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар нийт 289.4 тэрбум төгрөг төлөвлөлөө. Хөрөнгө оруулалтын зардлын 88.5 тэрбум төгрөгөөс 9 барилга байгууламжид 31.1 тэрбум төгрөг, 10 тоног төхөөрөмжид 51.8 тэрбум төгрөг, ТЭЗҮ-д 1.5 тэрбум төгрөг, их засварт 4.1 тэрбум төгрөг төсөвлөгдсөн. -Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн төслийг нэгтгэн хүргүүлэх хуулийн хугацаа болоогүй.	100
34	Арга хэмжээ 18.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, тайлагнах, гүйцэтгэлийг хянаж, санхүүжилтийн эрх нээлгэх, санхүүжилтийг олгоно.	-	Батлагдсан төсөл, арга хэмжээ, төлөвлөгөөний тоо	11	11	-ЦХИХХС-ын Улсын төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/02, төсөл, арга хэмжээний багцад задлах шийдвэрийг А/01, эрх шилжүүлэлтийг А/03 дугаар тушаалаар тус тус баталсан. -ЦХИХХС-ын багцын улсын төсвийн хөрөнгө оруулалтын мэдээг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 03/326 дугаартай албан бичгээр, 2024 онд ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03/132 дугаартай албан бичгээр тус тус Сангийн яаманд хүргүүлсэн.	100

						-ЦХИХХС-ын багцын хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлын төсөвт 35.7 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. 2025 оны 2 дугаар улирлын байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл гараагүй. МУЗГ-ын 233 дугаар тогтоолоор ТХААГ-т худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар шийдвэрлэсний дагуу 3 төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг батлуулж, хүргүүлсэн. -Улсын төсвийн хөрөнгө оруулалтын УТ2506700069 дугаартай Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ 8.4 тэрбум төгрөгийн төсөл 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдөр гэрээ байгуулагдсан. -Монгол Улсын төсвийн хөрөнгөөр Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар болон Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын багцад 2020-2022 онд хэрэгжсэн 5 төсөл, арга хэмжээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлт хангагдсан тул нийт 5 гэрээт ажлын чанарын баталгаанд байршуулсан 82,647,924 төгрөгийг яамны барьцаа хөрөнгийн 100900067350 тоот дансанд санхүүжилтийн эрх нээх хүсэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03/161 дугаартай албан бичгээр Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлж, санхүүжилтийн эрх нээлгэж гүйцэтгэгчид олгосон.	
35	Арга хэмжээ 18.3. Төсвийн шууд захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааг төлөвлөж, тайлагнана.	-	Батлагдсан төлөвлөгөөний тоо, тайлангийн тоо	2	2	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар Яамны 2025 оны урсгал төсвийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-д нийтэлсэн. Яамны урсгал зардалд нийтдээ 22 төсөл, арга хэмжээ, Цахим шилжилт арга хэмжээнд 60 арга хэмжээ, Инновац, өндөр технологид 18 арга хэмжээ төлөвлөгдсөн. Үүнээс шууд худалдан авалт 45, нээлттэй тендер шалгаруулалт 24, харьцуулалтын аргаар 30, нэг эх үүсвэрээс худалдан авалт 1 байна. Тендер шалгаруулалт 70 хувийн гүйцэтгэлтэй байна.	100

Зорилт 19. Салбарын нягтлан бодох бүртгэл, тайлагналын нэгдсэн зохицуулалтыг хангах, хэрэгжилтийг хангана.		-	Тоогоор	3 2 1	3 2 1	2 /1 хугацаа болоогүй/ 2 1	100
36	Арга хэмжээ 19.1. Төсвийн шууд захирагчийн 2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгүүлнэ.	-	Тайлангийн тоо	3	3	-2024 оны Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлан, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу иж бүрэн бэлтгэж, мөн хуулийн 8.9.1-т заасны дагуу 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 03/185 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлж, ТЭЗ-ын тайланд нэгтгүүлсэн. Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.1-т заасны дагуу ТЭЗ-ийн харьяа БНҮҮС, ӨНХС-ийн санхүүгийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/414 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн аудитын төлөвлөгөөг албажуулан Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. -Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2024 оны санхүүгийн тайланд өгсөн аудитын албан шаардлагын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 02/913 дугаартай албан бичгийг Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. -2025 оны эхний хагас жилийн тайлангийн хуулийн хугацаа болоогүй.	100
37	Арга хэмжээ 19.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргаж, Сангийн яам, Үндэсний аудитын газарт хүргүүлнэ.	-	Тайлангийн тоо	2	2	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа төсөвт 7, төрийн өмчит 5 байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, холбогдох хоорондын тооцоо, дансны дүн мэдээг тулган баталгаажуулсан. Шууд захирагчдын Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэн бэлтгэж, 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Үндэсний аудитын газарт хүргүүлж, хуулийн хугацаанд аудитаар	100

						баталгаажуулан тайлагнасан. Санхүүгийн нэгтгэсэн 2024 оны тайланг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/875 дугаартай албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн.	
38	Арга хэмжээ 19.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг аудитаар баталгаажуулан Засгийн газрын нэгтгэсэн тайланд нэгтгүүлнэ.	-	Тайлангийн тоо	1	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын 2024 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланг Монгол Улсын Засгийн газрын нэгтгэсэн тайланд нэгтгүүлэхээр 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/958 дугаартай албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн. Тайлант онд ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд харьяа төсөвт, төрийн эмчит байгууллагын нийт авлага 27.02 тэрбум төгрөг, богино хугацаат өр төлбөр 35.7 тэрбум төгрөг, 105.6 тэрбум төгрөгийн орлого хүлээн зөвшөөрч, үндсэн үйл ажиллагаа болон нийт /урсгал, хөрөнгийн/ зардалд 96.1 тэрбум төгрөг зарцуулж, нийт балансын хөрөнгө 512.8 тэрбум төгрөг, хуримтлагдсан үр дүн 41.7 тэрбум төгрөгөөр тайлагнасан болно. Мөн ТЕЗ-ын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 01/1291 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.	100
Зорилт 20. Төрийн сангийн тооцоо, яамны албан хаагчдын цалин, тэтгэмж, хөрөнгийн хөдөлгөөний бүртгэл хийх, хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлнэ.			Тоогоор	245	245	160	100
			Мөнгөн дүнгээр	12	12	6	
				-	5.1	2.2	
				20	тэрбум		
				16	20	15	
				2	16	21	
					2		
39	Арга хэмжээ 20.1. Шилэн дансны мэдээг цахим системд хуулийн хугацаанд оруулна.	-	Мэдээллийн тоо	245	245	Шилэн дансны тухай хуульд заасны дагуу 2025 оны 1-5 дугаар сарын нийт 32 төрлийн мэдээлэл /Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, Өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх сан, Сайдын багцын, яамны хөрөнгө оруулалтын мэдээ, мэдээлэл, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, 5 сая төгрөгөөс	100

						дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, сар бүрийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт/-ийг шилэн дансны мэдээллийн систем www.shilendans.gov.mn -д хуулийн хугацаанд мэдээлэн ил тод болгосон.	
40	Арга хэмжээ 20.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон шууд захирагчийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.	--	Хүргүүлсэн мэдээний тоо	12	12	Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу төсвийн шууд захирагчдын төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 02-ны дотор хүлээн авч баталгаажуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 06-ны дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд сайдын багцын урсгал зардлын төсөвт 82.7 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний зардлын төсөвт 35.7 тэрбум төгрөг нийт 118.4 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Сайдын багцын нийт урсгал төсвийн гүйцэтгэл 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 17.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.	100
41	Арга хэмжээ 20.3. Бүх нийтийн үйлчилгээний сангийн хөрөнгө төвлөрүүлэлт, тайлан баталгаажуулалт, төлбөр тооцоог хийж, бүртгэнэ.	-	Төвлөрүүлсэн орлогын хэмжээ (гүйцэтгэлээр)	Гүйцэтгэлээр	5.1 тэрбум төгрөг	Харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудтай тайлан нийлэн баталгаажуулж бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд 2.2 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг 130 хувийн гүйцэтгэлтэй байна. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд өр төлбөртэй байгаа 119 байгууллагатай нэг бүрчлэн холбогдож 27 байгууллагын 58.4 сая төгрөгийн авлагыг 100 хувь барагдуулсан. Харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөл эзэмшиж байх хугацаандаа Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.9 дэх заалт, Тусгай сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 354 дүгээр тогтоолоор батлагдсан "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журам"-ын 5.2, 5.4, 5.5 дахь хэсэгт тус тус заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд хөрөнгө	100

						төвлөрүүлэх үүрэгтэй 174 байгууллага руу 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 02/1086 дугаартай албан бичгээр хөрөнгө төвлөрүүлэх тухай мэдэгдэл хүргүүлсэн.	
42	Арга хэмжээ 20.4. Урсгал төсвийн хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийн эрхийг нээлгүүлнэ.	-	Төсвийн санхүүжилтийн эрхийн тоо	20	20	2025 оны эхний хасаг жилийн байдлаар Сангийн яамны Төрийн сангийн газарт 15 удаагийн нийт 4,903.8 сая төгрөгийн хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтийн эрх нээлгэх талаар албан бичиг хүргүүлсэн. Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулалд 5.9 сая төгрөг, олон улсын байгууллагын гишүүнчлэл хураамж 1,000.0 сая төгрөг, олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах 4.8 сая төгрөг, радио шугам, хиймэл дагуул, VPN ашиглалт 2,610.0 сая төгрөг, Цахим шилжилт арга хэмжээ 460.9 сая төгрөг Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээ 31.6 сая төгрөг, Инновац өндөр технологи арга хэмжээ 99.2 сая төгрөг, INTEL SAT ба REUTERS-ийн суваг арга хэмжээ 337.5 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг тус тус нээлгэсэн.	100
43	Арга хэмжээ 20.5. Албан хаагчдын цалин, тэтгэмжийг бодож олгох, нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татварын тайлангуудыг тайлагнана.	-	Тайлангийн тоо	16	16	Яамны дотоод журамд заасны дагуу сар бүрийн 8, 23-ны өдөр Төрийн албаны цалингийн нэгдсэн систем https://Payroll.gov.mn/ -д нийт албан хаагчдын цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс урамшуулал, хоол, унааны хөнгөлөлт, ээлжийн амралтын цалин, ХЧТА тэтгэмжийг сар бүр бодож олгов. 2025 оны 06 дугаар сарын байдлаар цалин хөлс 15 удаа, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж 6 удаа тооцоолж нийтдээ 21 удаа цалин хөлс, тэтгэмж, тооцоолж, удирдлагаар хянуулан баталгаажуулж, албан хаагчдад олгосон. Харьяа нийгмийн даатгалын хэлтэст сар бүрийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан НД7, Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт НД8 маягтын дагуу бэлтгэж дараа сарын 5-ны дотор тайлагнадаг бөгөөд нийт 5 удаа нийгмийн даатгалын	100

						тайлангийн https://portal.ndaatgal.mn/ системээр хугацаанд нь баталгаажууллаа. 2024 оны 1-р улирлын 86 албан хаагчаас суутгасан Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлан ТТ-11 маягтын дагуу татварын нэгдсэн https://etax.mta.mn/ системд тооцоолол хийж тайлагнасан.	
44	Арга хэмжээ 20.6. Хөрөнгийн тооллогыг хагас жил тутам зохион байгуулж, эд хөрөнгийг бүртгэх, шилжүүлэх, хасах, хүлээлцэх ажилд хяналт тавина.	-	Хөрөнгийн тооллогын тоо	2	2	Эд хөрөнгийн 2025 оны эхний хагас жилийн тооллогыг 06 дугаар сарын 10-25-ны өдрүүдэд зохион байгуулахаар Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/182 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Тооллогын бэлтгэл ажлын хүрээнд санхүү бүртгэлийн программд үндсэн хөрөнгө хөдөлгөөнийг бүрэн хийж дуусгасан.	50
Зорилт 21.Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлнэ			Тоогоор	3	6 6 1	I-IV улирал	100
45	Худалдан авах ажиллагааны сургалтад сурч, төгссөн байна.	-	Амжилттай төгсөгчдийн тоо	3	6	I-IV улирал	100
46	Төрийн албаны сургууль Удирдлагын академийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөрт хамрагдана.	-	Төгссөн албан хаагчдын тоо	-	6	Тус газраас Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 2, Дунд хугацааны давтан сургалтад 1 албан хаагч хамрагдсан. Монгол Улсын Улаан загалмайн нийгэмлэг, Онцгой байдлын ерөнхий газраас хамтран зохион байгуулсан "Гамшгийн эрсдэлийг бууруулах, эрт хариу арга хэмжээ, ач холбогдол, чиг хандлага" онол практикийн бага хуралд 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр оролцов.	100

47	Компанийн засаглалын чиглэлээр хамрагдана.	сургалтад	-	Хамрагдсан албан хаагчийн тоо	-	1	2025 оны сүүлийн хагас жилд хамрагдахаар төлөвлөсөн.	-
----	--	-----------	---	-------------------------------	---	---	--	---

Төлөвлөгөөг үнэлсэн:

Төрийн нарийн бичгийн даргын
Албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)

Тэмдэг

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

.....
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

.....
(гарын үсэг)

Тайлагнасан:

Төрийн захиргааны удирдлагын
газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Төсвийн шууд захирагч

..... /П.Алтан-Од/

(огноо)

.....

Нэгжийн дарга

/ /

(огноо)

.....

Нэгжийн дарга

/Д.Батбилэг/

.....

(огноо)